

4

**ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН  
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2021 оны 01 сарын 19 өдөр

Дугаар 1/02

Сүмбэр сум

"Хамтарсан багаар хүүхэд  
хамгааллын үйлчилгээ үзүүлэх нь" сургалт  
зохион байуулах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.4, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2017 оны А/173, А/251, А/3801 дугаар тушаалаар батлагдсан "Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам"-ын 2 дугаар зүйлийн 2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хамтарсан багаар хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх нь" сургалтыг зохион байуулах ажлын удирдамжийг 1 дүгээр хавсралтаар, төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дээрх арга хэмжээг зохион байгуулж үр дүнг тайлагнаж ажиллахыг Нийгмийн ажилтан (Ч.Анхтуяа)-д үүрэг болгосугай.


3. Дээрх үйл ажиллагаанд зарцуулагдах 968 660 (ёсөн зуун жаран найман мянга зургаан зуун жар) төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлаас гаргахыг нягтлан бодогч (Д. Оюунцэцэг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Ц.ОЮУНБИЛЭГ



Д:/Бичиг хэрэг /тушаал

ГБХЗХГазрын даргын 2021 оны  
01 сарын 19-ний өдрийн А/02  
дугаар тушаалын 1-р хавсралт



## "ХАМТАРСАН БАГААР ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ НЬ" СУРГАЛТЫН УДИРДАМЖ

Говьсүмбэр аймаг

### Нэг. Үндэслэл:

2020 онд Говьсүмбэр аймгийн хэмжээнд аймгийн Цагдаагийн хэлтсээс гаргасан судалгаагаар гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 25, зөрчилийн хэрэг 29 бүртгэгдсэн. Гэр бүлийн хүчирхийлэл нь хүний эрхийн хамгийн том зөрчлийн нэг төдийгүй үүний хохирогч нь дийлэнхдээ хүүхэд, эмэгтэйчүүд байдаг.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2017 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн А/173, А/251, А/3801 тушаалаар батлагдсан "Хамтарсан багийн ажиллах, санхүүжүүлэх журам"-д гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, хамгааллын үйлчилгээ үзүүлэх, нийгмийн ажлын үйлчилгээг анхан шатандаа сумдын хамтарсан баг үзүүлэхээр заасан. Иймээс гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох, хүчирхийллийн хохирогчдод нийгмийн ажлын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зайлшгүй шаардлага үүсээд байна.

### Хоёр. Зорилго:

Хамтарсан багийн хуулиар тусгайлан хүлээсэн чиг үүргийн хүрээнд нэгдсэн ойлголтыг өгч хамтарсан багийн гишүүдэд хүүхэд төвтэй нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх арга зүйн сургалтыг зохион байгуулж, чадавхжуулах.

### Гурав. Хамрах хүрээ:

Сумдын хамтарсан багууд

### Дөрөв. Хугацаа:

2021 оны 01 сарын 20-ны өдөр Баянтал суманд, , 01 сарын 21-ний өдөр Шивээговь суманд 01 сарын 26-ны өдөр Сүмбэр суманд тус тус зохион байгуулагдана.

### ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР:

№	Цаг	Үйл ажиллагаа	Хариуцах эзэн
1	09 <sup>00</sup> -10 <sup>30</sup>	Хамтарсан багийн ажиллах журам, гишүүдийн чиг үүрэг, хамтын ажиллагаа	Хүүхдийн эрхийн улсын байцаагч, Хүүхэд хамгааллын мэргэжилтэн Б.Шархүү
2	10 <sup>30</sup> -11 <sup>30</sup>	Хүүхэд хамгааллын тухай ойлголт, Хүүхэд хамгааллын тогтолцоо. Хүүхэд хамгааллын үйлчилгээний чиг хандлага	Нийгмийн ажилтан Ч.Анхтуяа
3	11 <sup>40</sup> -12 <sup>10</sup>	Мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулах. Мэдээлэл илрүүлэх, хүлээн авах	Нийгмийн ажилтан Ч.Анхтуяа


6

4	12 <sup>00</sup> -13 <sup>00</sup>	Хохирогчид сэтгэл зүйн анхны тусламж үзүүлэх арга зүй	Сэтгэл зүйч Г.Мөнхчимэг
5	14 <sup>00</sup> -15 <sup>00</sup>	Кейс төлөвлөлт хийх, алхмууд	Нийгмийн ажилтан Ч.Анхтуяа
6	15 <sup>00</sup> -16 <sup>00</sup>	Тусгай нөхцөл дэх кейс менежмент	Нийгмийн ажилтан Ч.Анхтуяа
7	16 <sup>00</sup> -17 <sup>00</sup>	Кейс дээр ажиллах /дадлага ажил/	Нийгмийн ажилтан Ч.Анхтуяа


### Зургаа. Үр дүн:

Хамтарсан багийн гишүүдийн хүүхэд төвтэй кейс үйлчилгээ үзүүлэх сургалтад хамрагдсанаар дараах үр дүн гарсан байна.

- Анхан шатны баримт бүрдүүлэлтийг журмын дагуу бүрдүүлэх чадварт суралцана.
- Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эрхийн хүчирхийллийн тохиолдолд анхан шатандаа мэргэжлийн үйлчилгээг чанартай өгөх арга зүйг эзэмшсэн байна.
- Хүчирхийллийн хохирогч хүүхдүүд хүүхдийн эрхийг хангасан үйлчилгээг авах нөхцөл боломж бүрдэнэ.
- Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа тогтмолжино.

Удирдамж боловсруулсан: Нийгмийн ажилтан  Ч.Анхтуяа

ГБХЗХГазрын даргын 2021 оны  
01 сарын 19-ний өдрийн  
дугаар тушаалын 4-р хавсралт



**"ХАМТАРСАН БАГААР ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ НЬ"**  
**СУРГАЛТЫН ТӨСӨВ**

Говьсүмбэр аймаг

2021.01.14

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Томилолт	ширхэг	6	26.500	159.000
2	Бензин /АИ92/	литр	34	1490	50.660
3	Маск	ширхэг	100	300	30.000
	Нийт				239.660
<b>Хамтарсан багт шаардлагатай бичиг хэргийн зардал</b>					
4	Бичгийн цаас	боодол	18	11000	198.000
5	Принтерийн хор	ширхэг	4	60.000	240.000
6	Хавтас /короно/	ширхэг	15	5.000	75.000
7	Нүхтэй хавтас	боодол	12	8.000	96.000
8	Хуудастай хавтас	ширхэг	30	4.000	120.000
	Нийт				729.000
	<b>Нийт төсөв</b>				<b>968.660</b>

ТӨСӨВ БОЛОВСРУУЛСАН: НИЙГМИЙН АЖИЛТАН *Ч.АНХТУЯА* Ч.АНХТУЯА